ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
# ТАРАГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 28 өдөр Дугаар А/21 Хүрэмт

## Шууд гэрээ байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, 34 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цагдаагийн хяналтын явуулын пост ӨВАТАСЗДТГ/2019001 барааг 7000000 (долоон сая) төгрөгөөр иргэн Өлзийхүү овогтой Намжил-Ойдовоос нийлүүлэхээр шууд гэрээ байгуулсугай.

2. Дээрх барааны төлбөр 7000000 (долоон сая) төгрөгийг сумын Орон нутгийн хөгжлийн сангаас гэрээний дагуу зарцуулахыг Санхүү албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч (Б.Саруул)-д зөвшөөрсүгэй.

3. Гэрээ байгуулж нийлүүлэлтийн явцад хяналт тавьж, санхүүжүүлэх зөвшөөрөл олгохыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Батцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Х.ДАШДЭЛЭГ

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ТАРАГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 03 сарын 06 өдөр Дугаар А/38 Хүрэмт

Тендер хүчингүй болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 01 дугаар зөвлөмжийн дагуу сумын Эрүүл мэндийн төвд шатахуун нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг хүчингүй болгосугай.

2. Тендер шалгаруулалтанд нэг ч оролцогч үнийн санал ирүүлээгүй тул шууд гэрээ байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн төв (Д.Энхбаатар)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Х.ДАШДЭЛЭГ

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТАРАГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 21 өдөр Дугаар А/45 Хүрэмт

Цагдаагийн хяналтын явуулын постыг хүлээж авах комисс байгуулах тухай

Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, хяналт шалгалтын тайлагналтын журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.5.10, 4.5.11-т заасныг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй "Сумын төвийн камержуулалт"-ын ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын ахлагч: Б.Батцэцэг-Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүд: Ш.Элбэгжаргал- ИТХурлын нарийн бичгийн дарга
Д.Амгаланзаяа-Сумын цагдаа
Ж.Батзориг- Байгаль орчны хяналтын улсын байцаагч
Б.Ундрах- Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн
Б.Заяадаваа- Нярав
Д.Бадамхорлоо- Иргэний төлөөлөл

2. Төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолт, гэрээнд заасны дагуу бараа, ажил, үйлчилгээг хүлээн авч, комиссын акт үйлдэн баталгаажуулахыг бараа, ажил, үйлчилгээ хүлээн авах комисс (Б.Батцэцэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Х.ДАШДЭЛЭГ

My.Doc A-4.Zahiramj ZD

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
# ТАРАГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 10 өдөр Дугаар А/67 Хүрэмт

**Шууд гэрээ байгуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, 34 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Тохижилт ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жилийн ажлын хүрээнд Байгаль орчны улсын байцаагчид мотоцикль ӨВАТАСЗДТГ(2019014 барааг 1800000 )Нэг сая найман зуун мянга(Нэг сая найман зуун мянга)төгрөгөөр иргэн Цэрэнбат овогтой Амгаланбаатараас нийлүүлэхээр шууд гэрээ байгуулсугай.

2. Дээрх барааны төлбөр 1800000(Нэг сая найман зуун мянга) төгрөгийг сумын Орон нутгийн хөгжлийн сангаас (улсын төсвийн санхүүжилтээр нэмэгдсэн) гэрээний дагуу зарцуулахыг Санхүү албаны дарга (Б.Саруул)-д зөвшөөрсүгэй.

3.Гэрээ байгуулж нийлүүлэлтийн явцад хяналт тавьж, санхүүжүүлэх зөвшөөрөл олгохыг Засаг даргын Тамгын газрын дарга(Б.Батцэцэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Х.ДАШДЭЛЭГ

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ТАРАГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 10 өдөр Дугаар А/67 Хүрэмт

Шууд гэрээ байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, 34 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Тохижилт ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жилийн ажлын хүрээнд Байгаль орчны улсын байцаагчид мотоцикль ӨВАТАСЗДТГ(2019014 барааг 1800000 )Нэг сая найман зуун мянга(Нэг сая найман зуун мянга)төгрөгөөр иргэн Цэрэнбат овогтой Амгаланбаатараас нийлүүлэхээр шууд гэрээ байгуулсугай.

2. Дээрх барааны төлбөр 1800000(Нэг сая найман зуун мянга) төгрөгийг сумын Орон нутгийн хөгжлийн сангаас (улсын төсвийн санхүүжилтээр нэмэгдсэн) гэрээний дагуу зарцуулахыг Санхүү албаны дарга (Б.Саруул)-д зөвшөөрсүгэй.

3.Гэрээ байгуулж нийлүүлэлтийн явцад хяналт тавьж, санхүүжүүлэх зөвшөөрөл олгохыг Засаг даргын Тамгын газрын дарга(Б.Батцэцэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Х.ДАШДЭЛЭГ

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТАРАГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 18 өдөр Дугаар А/61 Хүрэмт

Тендер хүчингүй болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Үнэлгээний хорооны 2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 02 дугаар зөвлөмжийн дагуу нийгмийн халамжийн 2019 оны хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг хүчингүй болгосугай.

2.Тендер шалгаруулалтанд нэг ч оролцогч үнийн санал ирүүлээгүй тул шууд гэрээ байгуулж ажиллахыг Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар (С.Ундрах ) -т зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА Х.ДАШДЭЛЭГ

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ТАРАГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 26 өдөр Дугаар 1/69 Хүрэмт

Шууд гэрээ байгуулах эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2019 оны 4 дүгээр 25-ны өдрийн 06 дугаар зөвлөмжийн дагуу Нийгмийн халамжийн 2019 оны хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх нийлүүлэгчээр "Дэлгэрэх сувд" ХХК-аар нийлүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээ байгуулж хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр нийгмийн халамжийн мэргэжилтэн (Т.Нямдаваа )-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Х.ДАШДЭЛЭГ

D.My.Doc.A-4 zahiramj ZD

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ТАРАГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 03 өдөр Дугаар А/72 Хүрэмт

Тендер гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 04 дүгээр сарын 25-ний өдрийн 05 дугаар зөвлөмжийн дагуу “Цэцэрлэгт хүрээлэн барих” ОНХС 201901001 ажлыг 40000000 (Дөчин сая) төгрөгөөр “ИДУМ” ХХК-аар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Дээрх ажлын төлбөрийг ОНХСангаас гэрээний дагуу зарцуулахыг Санхүү албаны дарга, ерөнхий нягтлан бодогч (Б.Саруул)-д зөвшөөрсүгэй.

3. Гэрээ байгуулж ажлын явцад хяналт тавьж, санхүүжүүлэх зөвшөөрөл олгохыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Батцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Х.ДАШДЭЛЭГ